



АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ ЧИГЛЭЛЭЭР ХЭРЭГЖҮҮЛСЭН
ХӨТӨЛБӨР АРГА ХЭМЖЭЭНИЙ ҮР ДҮН ХАНГАЛТГҮЙ БАЙНА

АУДИТЫН НЭР: “ХАЛАМЖААС ХӨДӨЛМӨР БОДЛОГЫН ХҮРЭЭНД
АЙМАГТ ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ЧИГЛЭЛЭЭР ХЭРЭГЖҮҮЛСЭН АРГА
ХЭМЖЭЭНИЙ ҮР ДҮН, ҮР НӨЛӨӨ”

АУДИТЫН КОД: АРА-2026/23-ШТА-ГА



Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор Т.Байгалмаа

Утас: 77333141 Цахим хаяг: Baigalmaat@audit.gov.mn

Аудитын менежер Н.Алтантуяа

Утас: 77332860 Цахим хаяг: Altantuyan@audit.gov.mn

Аудитор Н.Энхчимэг

Утас: 89113057 Цахим хаяг: Enkhchimegn@audit.gov.mn

Аудитор Н.Дашмягмар

Утас: 99164665 Цахим хаяг: Dashmyagmarn@audit.gov.mn

Архангай аймаг 2026 он

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг www.audit.mn цахим хаягаар авна уу.



Тайлан	Агуулга	
бэлтгэсэн:	Товчилсон үгийн тайлбар	3
Архангай аймаг	Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй	4-5
дахь Төрийн	Үндсэн мэдээлэл	5-6
аудитын газар	Аудитын тайлан	7-22
Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа	БҮЛЭГ.1 ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ ҮЙЛ АЖИЛЛАГААГ ХУУЛЬД ЗААСАН ШААРДЛАГЫН ДАГУУ ТООЦОО СУДАЛГААНД ҮНДЭСЛЭН ТӨЛӨВЛӨӨГҮЙ БАЙНА	
Аудитын менежер Н.Алтантуяа	<i>1.1.1 Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр хэрэгжүүлсэн хөтөлбөр, арга хэмжээ нь аймгийн дунд хугацааны бодлогын баримт бичигтэй уялдсан байна.</i>	
Аудитор Н.Энхчимэг Н.Дашмягмар	<i>1.1.2. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр богино хугацааны бодлогын зорилт, арга хэмжээг орон нутгийн хөгжлийн төлөвлөгөөнд тусгасан байна</i>	
2026 оны 07 дугаар сар Уг тайланг www.audit.mn сайтаас үзнэ үү.	<i>1.2.1. Хөдөлмөр эрхлэлтийн дэмжих хөтөлбөр, арга хэмжээнд зарцуулах хөрөнгийг бодитой төлөвлөөгүй байна</i>	
Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах зүйл байвал 7033-2860 дугаарын утас, 7033-3141 дугаарын факсаар харилцана уу	<i>1.2.2. Хөдөлмөр эрхлэлтийн дэмжих хөтөлбөр, арга хэмжээний хөрөнгийг бодит тооцоо судалгаанд үндэслэн хуваарилаагүй байна</i>	
Хаяг: Эрдэнэбулган сум Аймгийн ЗДТГ-ын байр 3-р давхар 314 тоот	БҮЛЭГ 2. ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ САНГИЙН ХӨРӨНГӨӨР ХЭРЭГЖҮҮЛСЭН ХӨТӨЛБӨР, АРГА ХЭМЖЭЭ НЬ САНГИЙН ҮНДСЭН ЗОРИЛГЫГ ХАНГАХУЙЦ ҮР ДҮНГ БИЙ БОЛГООГҮЙ БАЙНА	
	<i>2.1.1. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгийг батлагдсан төсөв, хөтөлбөр, арга хэмжээний дагуу зарцуулсан байна</i>	
	<i>2.1.2. Санхүүгийн дэмжлэгийг олон төсөлд хуваан олгож байгаа нь төслийн үр нөлөөг буруулж, ажлын байр нэмэгдүүлэх боломжийг алдагдуулж байна</i>	
	<i>2.1.3. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн хөтөлбөр, арга хэмжээний үр нөлөөг тооцож үнэлээгүй байна</i>	
	<i>2.1.4 Санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөлтийг 2023,2024 онд төлөвлөөгүйгээс 805.5 сая төгрөгийн эх үүсвэрийг дутуу бүрдүүлсэн байна</i>	
	<i>2.2.1 ХЭДС-ийн үйл ажиллагааны үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийгдээгүй байна</i>	
	<i>2.2.2. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг хэрэгжүүлсэн ч хяналтын үр нөлөө сул байна</i>	
	Дүгнэлт.....	
	Холбогдох байгууллагын санал	23
	Тайлан баталгаажуулсан тушаал.....	24
	Хавсралт:	25
		26



ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
МУЗГ	Монгол Улсын Засгийн газар
МУЕА	Монгол Улсын ерөнхий аудитор
ХХҮЕГ	Хөдөлмөр халамж үйлчилгээний ерөнхий газар
ААНБ	Аж ахуй нэгж байгууллага
ХХҮГ	Хөдөлмөр халамж үйлчилгээний газар
ХЭДС	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан
ХБИ	Хөгжлийн бэрхшээлтэй иргэн
ХШҮ	Хяналт-шинжилгээ, үнэлгээ
ХЭДС	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал

Хүснэгтийн товъёг:

№	Тайлбар	Хуудасны дугаар
1	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр хэрэгжүүлсэн арга хэмжээ ба бодлогын баримт бичигт тусгасан байдлын уялдаа	8
2	Аймгийн 2023-2025 оны жилийн хөгжлийн төлөвлөгөөнд тусгагдсан байдал	9
3	ХЭДС-аас 2023-2025 онд төсөл арга хэмжээнд хамрагдсан иргэдийн ажлын байрны мэдээлэл	17
4	ХЭДС-ийн 2023-2025 оны нийт орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл	19
5	ХЭДС-аас 2023 онд олгосон зээлийн эргэн төлөлтийн гэрээний төлөгдөөгүй дүн	20
6	ХЭДС-аас 2024-2025 онд олгосон санхүүгийн дэмжлэгийг зээлийн эргэн төлөлт	20

Дүрслэлийн товъёг:

№	Тайлбар	Хуудасны дугаар
1	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2023-2025 оны төлөвлөлт	10
2	ХЭДС-ийн хөрөнгийн батлагдсан төсөв, гүйцэтгэл	13
3	Хөдөлмөр эрхлэлтийн сургалтад хамрагдсан иргэдийн мэдээлэл	14
4	ХЭДС-аас 2023-2025 онд түр ажлын байранд хамрагдсан иргэдийн судалгаа	16
5	ХЭДС-аас 2023-2025 онд олгосон иргэн, ахмад, ХБИ-д олгосон санхүүгийн дэмжлэгийн судалгаа	17
6	Санхүүгийн дэмжлэгийн чиглэл ангилал	18
7	Бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд хийсэн ХШҮ	22



Аудитын нэр:

“Халамжаас хөдөлмөрт бодлогын хүрээнд аймагт хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн, үр нөлөө”

Аудитын код: АРА-2026/23-1/ШТА-ГА

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:

Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд “Аудитын жилийн төлөвлөгөө батлах тухай” МҮЕА-ын 2025 оны А/179 дугаар тушаал, “Аудитыг сэдэв батлах тухай” МҮЕА-ын 2025 оны А/173 дугаар тушаал, Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын 2026 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө, Монгол Улсын Ерөнхий Аудиторын баталсан тушаалыг үндэслэн хийлээ.

Аудитын зорилт:

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2023, 2024, 2025 оны үйл ажиллагааны хэрэгжилт, үр дүнд аудит хийн, дүгнэлт өгч, зөвлөмж боловсруулан дүнг Үндэсний аудитын газар болон аймгийн ИТХ, Засаг дарга, холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилго чиглэгдэнэ. Уг зорилгыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг хийлээ. Үүнд:

- Орон нутагт хэрэгжүүлэх хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаа (хөтөлбөр)-д зарцуулах хөрөнгийг хууль, тогтоомжид нийцүүлж, үндэслэлтэй төлөвлөсөн эсэх;
- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгөөр санхүүжүүлсэн үйл ажиллагаа (хөтөлбөр) үр дүнтэй хэрэгжсэн эсэх;

Аудитын хамрах хүрээ:

Аудитад Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал, аймгийн Засаг дарга, аймгийн Хөдөлмөр эрхлэлтийн зөвлөл, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2023, 2024, 2025 оны үйл ажиллагаа болон Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн үйл ажиллагаанд оролцогч ААНБ, иргэдийг хамруулан шалгалаа.

Аудитын арга зүй:

Аудитыг Аудитыг АДБОУС-100, 300, 400, 3000-3100, 4000, Монгол Улсын төрийн аудитын стандарт MNS 6817-5:2020 “Гүйцэтгэлийн аудитын зарчим”, MNS 6817-6:2020 “Нийцлийн аудитын зарчим”, MNS 6817-7:2020 “Гүйцэтгэлийн аудитын стандарт”, MNS 6817-8:2020 “Нийцлийн аудитын стандарт”, МҮЕА-ын 2020 оны А/106 тушаалаар батлагдсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”, 2021 оны А/69 “Гүйцэтгэлийн аудитын заавар, аргачлал батлах тухай”, А/71 дүгээр тушаалаар батлагдсан “Нийцлийн аудитын заавар, аргачлал”-ын дагуу аудитын зорилго, зорилт, асуудлын шинжилгээний асуултад хариулт өгөхөд шаардагдах нотлох баримтыг цуглуулж, дүн шинжилгээ хийх, харьцуулах, тулгах, түүвэрлэн хянах, нэгтгэх, холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа авах зэрэг арга зүйг ашиглан аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээний дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсрууллаа.

Аудитад ашигласан шалгуур үзүүлэлт:

Дараах хууль эрх зүйн актын холбогдох заалтуудыг аудитын шалгуур үзүүлэлт болгон ашиглав.



- ✓ Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль;
- ✓ Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль;
- ✓ Төсвийн тухай хууль;
- ✓ Төрийн хэмнэлтийн тухай хууль;
- ✓ Засгийн газрын 2011 оны 375 дугаар тогтоолоор баталсан “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих журам”;
- ✓ Засгийн газрын 2021 оны 340 дүгээр тогтоолоор батлагдсан “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас жижиг зээл олгох, түүнд батлан даалт гаргах, хүүг нь нөхөн төлөх, санхүүгийн дэмжлэг үзүүлэх журам”;
- ✓ Хөдөлмөр эрхлэлтийн Үндэсний зөвлөлийн 2017 оны 02 дугаар тогтоолоор батлагдсан “Аймаг, нийслэл, дүүргийн зөвлөлийн дүрэм”;
- ✓ Хөдөлмөр, нийгмийн хамгааллын Сайдын 2024 оны А/9 дүгээр тушаалаар батлагдсан “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны нэгдсэн удирдамж, зардлын жишиг хэмжээ”;

Аудит хийсэн багийн бүрэлдэхүүн, хугацаа:

Аудитыг аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа хянан удирдаж, аудитын менежер Н.Алтантуяа аудитын үе шатны чанарын хяналтыг хэрэгжүүлж, Аудитор Н.Энхчимэг, Н.Дашмягмар нар төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу 2026.05.11-2026.07.08-ны өдрийн хооронд хийж гүйцэтгэлээ.

Аудитын тайлангийн бүтэц, түүнд тусгах мэдээлэл:

Аудитын тайлан нь аудитын зорилт, дүн, дүгнэлт, зөвлөмж, холбогдох байгууллагын санал болон хавсралт хэсгээс бүрдэнэ. Гүйцэтгэлийн аудитын тайланг асуудлын шинжилгээний 4 дэх түвшний асуулт бүрд хариулт өгч тэмдэглэгээ хийсэн ба 3 дахь түвшний асуултын хүрээнд ерөнхийдөө ангилагдан бичсэн болно.

Үндсэн мэдээлэл:

Халамжаас хөдөлмөрт шилжих бодлогын талаар Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 2.1.3.8-т “Халамжаас хөдөлмөрт шилжих бодлоготой уялдуулан хөдөлмөр эрхлэлт, нийгмийн үйлчилгээний эрх зүйн орчныг шинэчилж, ядуурлыг бууруулах бодлого баримтална”, 2.1.3.9-д “Төрөөс үзүүлж байгаа нийгмийн халамж, тусламж, үйлчилгээг зөвхөн зорилтот бүлэгт чиглүүлнэ” гэж тусгажээ.

Энэхүү бодлогын зорилго нь хөдөлмөр эрхлэх боломжтой иргэдийг халамжийн мөнгөн дэмжлэгээс аажмаар хөдөлмөр эрхлэлтэд шилжүүлэх, тогтвортой орлоготой болгох, ядуурлыг бууруулах явдал юм.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн (цаашид ХЭДС гэх) үндсэн зорилго нь хүн амын зохистой хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, ажилгүйдлээс сэргийлэх, ажил хайгч болон зорилтот бүлгийн иргэдийн бизнесийг санхүүгийн болон бусад хэлбэрээр дэмжихэд чиглэгддэг.

Энэхүү үндсэн зорилгыг хэрэгжүүлэх хүрээнд дараах гол чиг үүргүүдийг хэрэгжүүлдэг:

- **Ажлын байр бий болгох:** Ажил олгогчдыг дэмжих, ажлын байрыг хадгалах болон шинээр ажлын байр бий болгох төсөл хөтөлбөрүүдийг санхүүжүүлэх.
- **Санхүүгийн дэмжлэг үзүүлэх:** Зорилтот бүлгийн иргэд, залуучууд болон ахмадуудын гарааны бизнес, өрхийн үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор хөнгөлөлттэй нөхцөл бүхий зээл олгох.



- **Хүний хөгжлийг дэмжих:** Ажилгүй иргэдийг хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцүүлэн мэргэжил олгох болон давтан сургах, ур чадварыг нь дээшлүүлэхэд шаардагдах зардлыг шийдвэрлэх

Аймгийн хөдөлмөр эрхлэлтийн дэмжих сангаас 5 хөтөлбөр 22 арга хэмжээнд 2023 онд 4294 иргэнд 1,917.2 сая төгрөг батлагдаж, гүйцэтгэлээр 4539 иргэнд 1,830.6 сая төгрөг, 2024 онд 4629 иргэнд 4,146.3 сая төгрөг батлагдаж, гүйцэтгэлээр 3546 иргэн 3,841.2 сая төгрөг, 2025 онд 1960 иргэнд 2,592.9 сая төгрөг батлагдаж, гүйцэтгэлээр 1734 иргэнд 2,460.1 сая төгрөгийг зарцуулжээ.

Архангай аймгийн ХЭДС-ийн 2023-2025 оны төлөвлөгөө, гүйцэтгэл

(сая төгрөг)

Арга хэмжээ	2023 он				2024 он				2025 он			
	Батлагдсан төсөв		Гүйцэтгэл		Батлагдсан төсөв		Гүйцэтгэл		Батлагдсан төсөв		Гүйцэтгэл	
	хүний тоо	мөнгөн дүн	хүний тоо	мөнгөн дүн	хүний тоо	мөнгөн дүн	хүний тоо	мөнгөн дүн	хүний тоо	мөнгөн дүн	хүний тоо	мөнгөн дүн
Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ	2414	19.1	2453	16	2213	18.5	1180	14.4	1200	50.3	903	14.1
Хөдөлмөрт бэлтгэх сургалтын үйл ажиллагаа	727	49.1	694	41.5	735	106.4	505	37.6	355	22.9	258	13.4
Санхүүгийн дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	199	1282.8	237	1234.2	388	3138.5	407	3119.7	212	2,171.9	304	2150.5
Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаа	126	163	118	152.6	128	144	91	138.3	72	213.5	96	202.2
Түр ажлын байрны дэмжих үйл ажиллагаа	822	347.2	1037	344.4	1155	499.4	1118	466.3	120	81.6	173	69.3
ЗГ-аас болон ХЭҮЗ-ийн шийдвэрээр батлан хэрэгжүүлэх хөтөлбөр ба арга хэмжээ					10	178.9	245	24.4	1	28.5		3.5
Үйл ажиллагааны зардал	6	56		41.9		60.6		40.5		24.2		7.1
Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны зардлын дүн	4294	1917.2	4539	1830.6	4629	4146.3	3546	3841.2	1960	2592.9	1734	2460.1

Эх сурвалж:ХХҮГ-ын 2023-2025 оны тайлан

Ажил хайгч иргэдийг ажил олгогчийн эрэлт, хэрэгцээнд нийцсэн тохирох ажлын байранд зуучлах үйлчилгээний хэрэгжилтийг хангах арга хэмжээний хүрээнд /Эх сурвалж:Хөдөлмөр эрхлэлтийн цахим e-job системээс/ :

- ✓ 2023 онд 745 ажил олгогчоос 2,814 ажлын байрны захиалга авч, 1,354 иргэнийг ажилд зуучилсан бөгөөд үүний 853 иргэн буюу 62.9 хувь нь байнгын болон улирлын ажлын байранд,
- ✓ 2024 онд 726 ажил олгогчоос 5132 ажлын байрны захиалга авч, 1367 иргэнийг ажилд зуучилсан бөгөөд үүний 1200 иргэн буюу 87.7 хувь нь байнгын болон улирлын ажлын байранд,
- ✓ 2025 онд 761 ажил олгогчоос 1815 ажлын байрны захиалга авч, 969 иргэнийг ажилд зуучилсан ба үүний 715 иргэн буюу 73.7 хувь нь байнгын болон улирлын ажлын байранд тус тус зуучилсан байна. Өмнөх оноос ажлын байрны захиалга буурсан нь хөдөлмөр эрхлэлтийн дэмжих сангаас хэрэгждэг нийтийг хамарсан ажлын санхүүжилт олгоогүйтэй холбоотой байна



Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйлчилгээнд 2025 оны байдлаар 302 иргэн хамрагдсанаас бүлгийн зөвлөгөө өгөх сургалтад 13 бүлгийн 195 иргэн, ганцаарчилсан зөвлөгөө өгөх үйлчилгээнд 107 иргэн хамрагджээ.



БҮЛЭГ.1 ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ ҮЙЛ АЖИЛЛАГААГ ХУУЛЬД ЗААСАН ШААРДЛАГЫН ДАГУУ ТООЦОО СУДАЛГААНД ҮНДЭСЛЭН ТӨЛӨВЛӨӨГҮЙ БАЙНА

1.1. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр арга, хэмжээг бодлогын түвшинд үйл ажиллагааны хөтөлбөр, төлөвлөгөөтэй уялдуулсан байна

1.1.1 Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр хэрэгжүүлсэн хөтөлбөр, арга хэмжээ нь аймгийн дунд хугацааны бодлогын баримт бичигтэй уялдсан байна.

Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3¹, 5.2.12², 6 зүйлийн 6.10.4³-т заасны дагуу Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт хөдөлмөр эрхлэлтийг дэмжих талаар баримтлах бодлоготой уялдуулан хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлийн 7 хөтөлбөр, төсөл, арга хэмжээг аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн хөгжлийн 2023-2025 оны жилийн төлөвлөгөөнд тусгаж бодлогын баримт бичгийн уялдааг хангасан байна.

Хүснэгт 1. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр хэрэгжүүлсэн арга хэмжээ ба бодлогын баримт бичигт тусгасан байдлын уялдаа

№	Бодлогын чиглэл	Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр	Аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр
1	Зорилтот бүлгийн иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих	4.1.4.хүн амын тодорхой зорилтот бүлгүүдийн хүсэл сонирхол, эрх ашгийг төрийн бодлого, шийдвэрт тусгуулах ажлыг зохион байгуулна.	2.8. Нийгмийн халамжийн үйлчилгээний чанарыг нэмэгдүүлж, зорилтот бүлгийн иргэдийн бие даан амьдрах чадварыг сайжруулна.
2	Орлого багатай иргэдийг мэргэжлийн ур чадвар олгох, хөдөлмөрт бэлтгэх	2.4.11. Орлого багатай өрхийн ажил эрхлэхгүй байгаа насанд хүрсэн гишүүдийг мэргэшил эзэмшүүлэх, ур чадварыг нь ахиулах сургалтад хамруулж хөдөлмөр эрхлэлтийг дэмжинэ.	2.7.3. Бага дунд орлоготой иргэдийг мэргэшил эзэмшүүлэх, ур чадварыг нь ахиулах сургалтад хамруулж хөдөлмөр эрхлэлтийг дэмжинэ.
3	Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, зөвлөгөө өгөх, дадлагуулах	2.4.13 Хүүхэд, залуучууд, гэр бүлд чиглэсэн төрийн бодлогыг хэрэгжүүлж, сургалт нөлөөлөл, хөгжлийн үйлчилгээг сайжруулна.	2.6.1 Залуучуудын боловсролын болон мэргэжлийн хөгжилд дэмжлэг үзүүлэх, олон нийтийн үйл ажиллагааны оролцоог дэмжинэ.
4	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ажлын байрыг нэмэгдүүлэх	4.1.4. "Иргэний танхим"-ын үйл ажиллагааг сэргээн эрчимжүүлж, "Ахмадаа сонсьё", "Хүүхдээ сонсьё", "Хөгжлийн бэрхшээлтэй иргэдээ сонсьё" зэрэг арга хэмжээгээр дамжуулан хүн амын тодорхой зорилтот бүлгүүдийн хүсэл сонирхол, эрх ашгийг төрийн бодлого, шийдвэрт тусгуулах ажлыг зохион байгуулна.	2.5.4 Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжин, сургалтад хамруулах, ажлын байранд зуучлах ажлыг зохион байгуулна.
5	Жижиг, дунд, бичил бизнес эрхлэгчдийг дэмжих	3.2.17. Орон нутгийн түүхий эд нөөцөд тулгуурласан, жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх, жижиг дунд үйлдвэр хөгжүүлэх сан, сум хөгжүүлэх сан бусад зээлийн бодлогоор дэмжинэ.	3.14.1. Орон нутгийн эрэлт хэрэгцээнд тулгуурлан хөнгөн үйлдвэрийг хөгжүүлж, тогтвортой ажлын байр шинээр бий болгосон жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдийг бодлогоор дэмжинэ.
6	Санхүүгийн дэмжлэг олгох, хувиараа хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх	2.4.9. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн төсөл хөтөлбөрүүдийг орон нутагт үр дүнтэй хэрэгжүүлж, өрхийн орлогыг нэмэгдүүлнэ.	2.7. Ажлын байрны тоог нэмэгдүүлнэ.
7	Ажил олгогчийг дэмжих урамшууллын арга хэмжээ	-	2.6.4. Залуусыг гарааны бизнес эрхлэх нөхцөл, боломжоор хангана.

1.1.2. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр богино хугацааны бодлогын зорилт, арга хэмжээг орон нутгийн хөгжлийн төлөвлөгөөнд тусгасан байна

¹ Бодлого төлөвлөлтийн нэгдмэл, цогц, харилцан уялдаатай байх,

² Төлөвлөлтийн дээрээс доош, доороос дээш чиглэх тэнцвэрийг хангах зарчим" гэж "дээрээс доош" төлөвлөх буюу нэгдсэн зорилго, зорилтыг дэвшүүлж салбар болон бүс нутгуудад хэрэгжүүлэх, "доороос дээш" төлөвлөх буюу төр, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтын төсөл хөтөлбөрүүдийн саналыг нэгтгэн, нэгдмэл зорилго, зорилтыг тодорхойлж төлөвлөхийг

³ "Орон нутгийн төсөв нь аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд чиглэсэн байх"



Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.10.4⁴, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 30 зүйлийн 30.2.1⁵, 30.3.1⁶, 30.3.2⁷, 30.3.3⁸ дахь заалтуудад хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн уялдааг хангах, хөдөлмөр эрхлэлтийн эрэлт хэрэгцээг тодорхойлж, төсөвт тусгуулах талаар жил бүр санал боловсруулах, ХЭДС-ийн санхүүжилтийг төсөвт тусган батлан ажиллах талаар аймгийн ИТХ болон Засаг даргын бүрэн эрхийг хуулиар тогтоосон байна.

Аймгийн хэмжээнд 2023-2025 онд Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлийн 7 арга хэмжээг богино хугацааны буюу тухайн жилийн хөгжлийн төлөвлөгөөнд тусгаж уялдуулжээ.

Хүснэгт-2 Аймгийн 2023-2025 оны жилийн хөгжлийн төлөвлөгөөнд тусгагдсан байдал

№	Бодлогын чиглэл	Аймгийн хөгжлийн 2023 оны төлөвлөгөө	Аймгийн хөгжлийн 2024 оны төлөвлөгөө	Аймгийн хөгжлийн 2025 оны төлөвлөгөө
1	Зорилтот бүлгийн иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих	1.4.11 Зорилтот бүлэгт чиглэсэн хөдөлмөр хэрэгжүүлж, хүн амын бүлгүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих замаар ажлын байрыг бий болгох	97. Зорилтот бүлгийг хэрэгцээнд нийцсэн халамжийн үйлчилгээнд бүрэн хамруулна.	1.1.1.Зорилтот гэр бүлийг сонгон авч хариу үйлчилгээ үзүүлэх, эрсдэлийг бууруулах
2	Орлого багатай иргэдийг мэргэжлийн ур чадвар олгох, хөдөлмөрт бэлтгэх	1.4.9 Орлого багатай иргэдэд чиглэсэн мэргэжлийн ур чадвар олгох, мэргэшүүлэх арга хэмжээнд хамруулах	-	-
3	Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, зөвлөгөө өгөх, дадлагажуулах	1.4 Гэр бүл, хүүхэд, залуучуудын эрхийг хамгаалж, ажлын байрыг нэмэгдүүлэн, хөдөлмөр эрхлэлтийг дэмжин, нийгмийн хамгааллыг зорилтот бүлэгт чиглүүлж, халамжаас хөдөлмөрт шилжих бодлого хэрэгжүүлнэ.	66. Орон нутагт угсаатан ястны онцлог бүхий сонгодог, орчин үеийн уран бүтээл туурвин, алслагдсан сумын иргэд хүүхэд залуучуудад хүргэхэд бүх талын дэмжлэг үзүүлэх	10.4.1. Оюутан, залуучуудын нийгмийн идэвх, оролцоог дэмжих орчныг нэмэгдүүлнэ.
4	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ажлын байрыг нэмэгдүүлэх	-	98. Өрхийн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлдэг хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг нэмэгдүүлэх	10.1.1.2. Ахмад настан болон хөгжлийн бэрхшээлтэй иргэнд үзүүлэх тусламж, хөнгөлөлт
5	Жижиг, дунд, бичил бизнес эрхлэгчдийг дэмжих	2.2.11 Жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн бараа бүтээгдэхүүний борлуулалтын орлогыг бүтээгдэхүүнийг сурталчлах зорилгоор “Архангай түншлэл” арга хэмжээг зохион байгуулах	213. Жижиг дунд үйлдвэрлэл хөгжүүлэх сан, хоршоо хөгжүүлэх сангаас хөнгөн үйлдвэрүүдэд хөнгөлөлттэй зээл олгох	7.1.4.1. Жижиг, дунд үйлдвэрлэлийн бүтээгдэхүүнийг сурталчлах, борлуулалтыг дэмжих
6	Санхүүгийн дэмжлэг олгох, хувиараа хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх	2.1.6 Иргэдийн санхүүгийн суурь мэдлэгийг Сургалтад дээшлүүлэх сургалтыг танхимын болон хамрагдсан зохион байгуулах	100. Санхүүгийн дэмжлэгт хамрагдсан иргэдэд түрээсийн дэмжлэг үзүүлэх	7.1.3.3. Санхүүгийн дэмжлэг авч хувиараа хөдөлмөр эрхэлж буй иргэдийг дэмжинэ
7	Ажил олгогчийг дэмжих урамшууллын арга хэмжээ	-	99. Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд борлуулалтын болон түрээсийн дэмжлэг үзүүлэх	1.3.4. Ажил олгогчийг дэмжих урамшууллын арга хэмжээ хэрэгжүүлнэ.

“Халамжаас хөдөлмөрт” шилжүүлэх бодлогын хүрээнд 2023 онд орон нутгийн төсвөөс ХЭДС-д хөрөнгө хуваарилаагүй, зөвхөн улсын төсвөөс хуваарилсан хөрөнгийн хэмжээнд үйл ажиллагаагаа явуулсан байна. Харин Аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.6.4-д “Залуусыг гарааны бизнес эрхлэх нөхцөл,

⁴ Засаг дарга сум, дүүргийн түвшинд хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн уялдааг хангах, үйл ажиллагааг зохицуулах, хэрэгжилтэд хяналт тавих;

⁵ энэ хуулийн 22.1.2-т заасан хөрөнгийг аймаг, нийслэл, дүүргийн төсөвт жил бүр тусган батлах;

⁶ 30.3.1.энэ хуулийн 22.1.2-т заасан хөрөнгийг аймаг, нийслэл, дүүргийн төсөвт тусгуулах талаар жил бүр санал боловсруулах;

⁷ 30.3.2.хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ, арга хэмжээг хэрэгжүүлэх ажлыг уялдуулан зохион байгуулах, хянах;

⁸ 30.3.3.хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээнд хамрагдах ажил олоход хүндрэлтэй иргэдийн талаарх мэдээлэл, судалгааг гаргаж, хөдөлмөр эрхлэлтийн хэрэгцээг тодорхойлох, хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээнд хамруулах



боломжоор хангана” гэсэн арга хэмжээний хүрээнд 2024 онд 5.0 сая, 2025 онд 10.0 сая төгрөгийг төлөвлөж, зарцуулсан байна.


1.2. Аймгийн зөвлөл нь чиг үүргээ хэрэгжүүлээгүй, орон нутгийн хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээ, хүн ам, ажилгүйдлийн түвшинд тооцоо судалгаа хийж оновчтой төлөвлөөгүй байна

1.2.1. Хөдөлмөр эрхлэлтийн дэмжих хөтөлбөр, арга хэмжээнд зарцуулах хөрөнгийг бодитой төлөвлөөгүй байна

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрүүдийн төсвийн төслийг боловсруулахдаа өмнөх оны төсвийн гүйцэтгэл, тайлант оны хүлээгдэж буй гүйцэтгэлд үндэслэн боловсруулдаг бөгөөд Аймгийн ХХҮГ-аас төсвийн төслийг 2023 онд 1,985.2 сая, 2024 онд 1,982.3 сая, 2025 онд 2,485.6 сая төгрөгийн саналыг хүргүүлснээс ХХҮЕГ-ын даргын 2023 оны А/37, 2024 оны А/67, 2025 оны А/30 дугаар “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн төсвийн хуваарь батлах тухай” тушаалаар 2023 онд 1,864.7 сая төгрөг, 2024 онд 1,086.2 сая төгрөг, 2025 онд 1,545.6 сая төгрөг анх батлагдсан байна.

Харин төсвийн тодотголоор 2023 онд 1,917.2 сая төгрөг, 2024 онд 4,146.3 сая төгрөг, 2025 онд 2,592.9 сая төгрөг болгож өсгөж баталжээ.

Дүрслэл-1: Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2023-2025 оны төлөвлөлт



ХЭДС-ийн 2023-2025 оны төсвийн төлөвлөлтөд дүн шинжилгээ хийхэд:

- 2023 онд анх батлагдсан төсөв (1,864.7 сая ₮) нь төсвийн төслийн саналаас (1,985.2 сая ₮) 120.5 сая төгрөгөөр бага байсан бол тодотголоор 1,917.2 сая төгрөг болж 52.5 сая төгрөгөөр өсгөсөн,
- 2024 онд анх батлагдсан төсөв (1,086.2 сая ₮) нь төсвийн төслийн саналаас (1,982.3 сая ₮) бараг хоёр дахин бага байсан бол тодотголоор 4,146.3 сая төгрөг болж 3.8 дахин өссөн байна. Энэ нь 2023 онд аймгийн хэмжээнд өвөлжилт хүндэрч, мал ихээр хорогдож, зуд болсонтой холбоотойгоор төсвийн тодотголоор малжуулах хөтөлбөр болон бусад хөтөлбөрүүдэд төсвийг нэмэгдүүлж тодотгосонтой холбоотой байна.
- 2025 онд анх батлагдсан төсөв (1,545.6 сая ₮) нь төсвийн төслийн саналаас (2,485.6 сая ₮) 940.0 сая төгрөгөөр багаар батлагдсан бол төсвийн тодотголоор 2,592.9 сая төгрөг болж 1,047.3 сая төгрөгөөр өсгөж, анхны төсвийн саналаас өсгөж баталсан байна.

Төсвийн төслийг боловсруулахдаа шаардлагатай дүн шинжилгээ, тооцоо судалгаа хийсэн эсэхийг нягтлахад Төсвийн тухай хуулийн 27⁹ дугаар зүйлд заасан шаардлагыг бүрэн хангаж, төсвийн төслийг боловсруулсан эсэх нь баримтаар нотлогдохгүй байна.

Мөн орон нутгийн хэмжээнд хөдөлмөр эрхлэлтийн эрэлт хэрэгцээ, зорилтот бүлгийг тодорхойлох, ажил олоход хүндрэлтэй иргэдийн талаарх мэдээлэл судалгаа, шинжилгээ

⁹ Төсвийн төсөл боловсруулахад тавигдах шаардлага



хийгдээгүй Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 30.3.3¹⁰-д заасан чиг үүргийг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

Хуульд заасан судалгаа, шинжилгээний суурьгүйгээр төсөв төлөвлөгдсөнөөс хөтөлбөр, арга хэмжээний хүрэх үр дүн тодорхойгүй, санхүүжилтийн тооцоо үндэслэлгүй байх, шинээр бий болох ажлын байрны тоо болон нийгэм, эдийн засгийн үр өгөөжийг урьдчилан тооцох, үнэлэх боломж хязгаарлагдсан байна.

Аудитаас хөдөлмөр эрхлэлтийн дэмжих арга хэмжээнд хамрагдах ажил олоход хүндрэлтэй иргэдийн талаарх мэдээлэл, судалгааг гаргаж, хөдөлмөр эрхлэлтийн хэрэгцээг тодорхойлох, хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ, хөдөлмөр эрхлэлтийн дэмжих арга хэмжээнд бүрэн хамруулах талаар бодит тооцоо судалгаанд үндэслэн төсвийн төслийг боловсруулах арга хэмжээ авч ажиллах албан шаардлагыг аймгийн Хөдөлмөр эрхлэлтийн аймгийн зөвлөлд хүргүүлээ.

1.2.2. Хөдөлмөр эрхлэлтийн дэмжих хөтөлбөрийн хөрөнгийг орон нутгийн хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээ, хүн ам, ажилгүйдлийн түвшинд судалгаа тооцоо хийхгүйгээр жигд хуваарилсан байна

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 28.1¹¹-т заасны дагуу аймгийн Засаг даргын 2023.03.23-ны өдрийн А/136 захирамжаар аймгийн Засаг даргаар ахлуулсан 9 хүний бүрэлдэхүүнтэй, 2025.02.21-ны өдрийн А/19 дугаар захирамжаар аймгийн Засаг даргын орлогчоор ахлуулсан хөдөлмөр эрхлэлтийн дэмжих аймгийн зөвлөлийг 9 хүний бүрэлдэхүүнтэй шинэчлэн байгуулжээ.

Аймгийн хөдөлмөр эрхлэлтийн зөвлөлийн эрх, үүргийг Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2017 оны 02 дугаар тогтоолоор баталсан “Хөдөлмөр эрхлэлтийн аймаг, нийслэл, дүүргийн зөвлөлийн дүрэм”-д заасан бөгөөд тус зөвлөл нь “Хөдөлмөр эрхлэлтийн дэмжих хөтөлбөр, арга хэмжээнд хамрагдах сумдын төсвийн хуваарийг баталж байна.

ХХҮЕГ-ын даргын тушаалаар 2023-2025 онд 22 төсөл арга хэмжээнд 8,656.4 сая төгрөгийг зарцуулахаар баталсныг аймгийн Хөдөлмөр эрхлэлтийн зөвлөлийн 2023 оны 01, 2024 оны 02, 03, 2025 оны 03 дугаар зөвлөлийн хуралдаанаар малжуулах төсөл хөтөлбөр, иргэн, ахмад, ХБИ-д олгох санхүүгийн дэмжлэгийг сум бүрд тэнцүү хэмжээгээр хуваарилсан бол сургалт, түрээс, борлуулалт, ажил олгогчийн дэмжлэгийг батлагдсан нийт дүнгээр хуваарилалтыг хийжээ.

Аймгийн хөдөлмөр эрхлэлтийн зөвлөл нь хөдөлмөр эрхлэлт, дэмжих хөтөлбөрүүдэд хамрагдах сумдын хуваарийг тухайн хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээ, орон нутгийн хүн ам, ажилгүйдлийн түвшин зэрэг бодит тооцоо, судалгаа мэдээлэлд үндэслэхгүйгээр 2023-2025 онуудад улсын төсвөөс олгосон санхүүжилтийг сум бүрд ижил дүнгээр хуваарилсан байна.

Өөрөөр хэлбэл: Сумдын хуваарилалтыг тухайн сумын хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээ, хүн ам, ажилгүйдлийн түвшин зэрэг бодит үзүүлэлтэд үндэслэлгүйгээр зөвхөн тэнцүү дүнгээр хуваарилсан нь “хэрэгцээнд суурилсан” бус “жигд хуваах” зарчмаар ажилласныг харуулж байна.

¹⁰ хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээнд хамрагдах ажил олоход хүндрэлтэй иргэдийн талаарх мэдээлэл, судалгааг гаргаж, хөдөлмөр эрхлэлтийн хэрэгцээг тодорхойлох, хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээнд хамруулах;

¹¹ Засгийн газар, ажил олгогч болон ажилтны эрх, хууль ёсны ашиг сонирхлыг төлөөлөн хамгаалах улсын хэмжээний байгууллагын төлөөлөл бүхий Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний болон аймаг, нийслэл, дүүргийн зөвлөлийг байгуулж, ажиллуулна”



Түүнчлэн аймгийн ХХҮГ нь тухайн жилийн төсвийн тодотголоор баталсан нэмэлт санхүүжилтийг аймгийн хөдөлмөр эрхлэлтийн зөвлөлөөр хэлэлцүүлэлгүйгээр сумдад шууд хуваарилсан байна. Энэ нь Хөдөлмөр эрхлэлтийг үндэсний зөвлөлийн 2017 оны 02 дугаар тогтоолоор баталсан “Хөдөлмөр эрхлэлтийн аймаг, нийслэл, дүүргийн зөвлөлийн дүрэм”-ийн 2.1.7¹² дахь заалттай нийцэхгүй байна.

Аудитаас хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгийг сум, орон нутгийн хүн амын ажилгүйдлийн түвшин, хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээг хангах бодлого чиглэлийг харгалзан, бодит тооцоо судалгаанд үндэслэн хуваарилах арга хэмжээ авах албан шаардлагыг аймгийн Хөдөлмөр эрхлэлтийн зөвлөлд хүргүүлээ.

Төсвийн тодотголоор 2023 онд 52.5 сая төгрөг, 2024 онд 3,060.1 сая төгрөг, 2025 онд 1,047.3 сая төгрөгийн нэмэгдэж батлагдсан санхүүжилтийг хуваарилах үйл ажиллагаанд ил тод, хамтын шийдвэр гаргах зарчим алдагдаж, хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээ, орон нутгийн хүн ам, ажилгүйдлийн түвшин зэргийг харгалзан батлах, бодлого чиглэл, зорилтот бүлгийн эрэлттэй уялдуулан оновчтой хуваарилах боломжийг хязгаарласан байна.

БҮЛЭГ 2. ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ САНГИЙН ХӨРӨНГӨӨР ХЭРЭГЖҮҮЛСЭН ХӨТӨЛБӨР, АРГА ХЭМЖЭЭ НЬ САНГИЙН ҮНДСЭН ЗОРИЛГЫГ ХАНГАХУЙЦ ҮР ДҮНГ БИЙ БОЛГООГҮЙ БАЙНА

2.1. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас хэрэгжүүлсэн хөтөлбөр, арга хэмжээний үр дүнд ажлын байр бодитой нэмэгдээгүй байна

2.1.1. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгийг батлагдсан төсөв, хөтөлбөр, арга хэмжээний дагуу зарцуулсан байна

Аймгийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас 5 хөтөлбөр 22 арга хэмжээнд 2023-2025 онуудад нийт 10883 иргэнд 8,656.4 сая төгрөгийг зарцуулахаар баталж гүйцэтгэлээр 10819 иргэнд 8,131.9 сая төгрөгийг зарцуулсан байна Сангийн хөрөнгийн зарцуулалтыг хөтөлбөр, арга хэмжээ тус бүрээр авч үзвэл:

Дүрслэл-2: ХЭДС-ийн хөрөнгийн батлагдсан төсөв, гүйцэтгэл

¹² Хөдөлмөр эрхлэлт дэмжих хөтөлбөрүүдэд хамрагдах сум, хорооны хуваарийг тухайн хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээ, орон нутгийн хүн ам, ажилгүйдлийн түвшин зэргийг харгалзан батлах, бодлого чиг гаргах



АЙМГИЙН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ САН



5 хөтөлбөр



22 арга хэмжээ

ОН	БАТЛАГДСАН	ГҮЙЦЭТГЭЛ	ТАЙЛБАР
2023 	4294 иргэнд 1917.2 сая төгрөг	4539 иргэнд 1830.6 сая төгрөг	✓ 2023 онд 4294 иргэнд 1917.2 сая төгрөгийн санхүүжилт батлагдсанаас гүйцэтгэлээр 4539 иргэнд 1830.6 сая төгрөгийг зарцуулсан байна.
2024 	4629 иргэнд 4146.3 сая төгрөг	3546 иргэнд 3841.2 сая төгрөг	✓ 2024 онд 4629 иргэнд 4146.3 сая төгрөгийн санхүүжилт батлагдаж, гүйцэтгэлээр 3546 иргэнд 3841.2 сая төгрөгийг зарцуулжээ.
2025 	1960 иргэнд 2592.9 сая төгрөг	1734 иргэнд 2460.1 сая төгрөг	✓ 2025 онд 1960 иргэнд 2592.9 сая төгрөгийн санхүүжилт батлагдсанаас гүйцэтгэлээр 1734 иргэнд 2460.1 сая төгрөгийг зарцуулсан байна.



Аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас 5 хөтөлбөр, 22 арга хэмжээг хэрэгжүүлж, 2023-2025 онд нийт **9819** иргэнд **8,131.9** сая төгрөгийн санхүүжилт зарцуулсан байна.

✓ **Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ:**

Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээний хөтөлбөр нь хөдөлмөрийн зах зээлд оролцоход хүндрэлтэй бүлгийн иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, ажилгүйдлийн эрсдэлийг бууруулах, тэднийг ажил, мэргэжлийн чиг баримжаа болон хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээнд хамруулах зорилготой байна.

Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээний ганцаарчилсан, бүлгээр, ажилд зуучлах, хөдөлмөр эрхлэлтийн чадавхыг үнэлэх, хөдөлмөр эрхлэлтийн төлөвлөгөө боловсруулах 5 арга хэмжээнд 2023 -2025 онд нийт **6579** иргэдэд **44.8** сая төгрөгийн сургалтын зардал зарцуулсан байна.

Сургалт зохион байгуулах сургалтын байгууллагыг ХХҮЕГ-аас сонгон шалгаруулж, орон нутгийн Хөдөлмөр халамж үйлчилгээний газар нь гэрээ байгуулан гэрээний үүргийн биелэлтэд хяналт тавьдаг бөгөөд тус байгууллагаас сургалтад хамрагдсан иргэд нь хөдөлмөр эрхлэлтэд шилжсэн, ажилд зуучлагдаж тогтвортой ажлын байртай болсон эсэхэд хяналт хэрэгжүүлээгүй байна. Иймд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт зарцуулсан хөрөнгийн бодит үр дүн, үр нөлөөг үнэлэх боломжгүй байна.

• **Хөдөлмөрт бэлтгэх сургалтын үйл ажиллагаа:**

Хөдөлмөрт бэлтгэх сургалтын үйл ажиллагаанд суурь ур чадвар, танхимын болон үйлдвэрлэл дээрх мэргэжлийн сургалт, аж ахуй эрхлэлтийн сургалт, залуучуудын сургалт, зөвлөгөө, эмэгтэйчүүдэд зориулсан богино хугацааны ур чадварын сургалтуудыг зохион байгуулж 2023-2025 онд нийт **1330** иргэдийг хамруулан **92.2** сая төгрөгийг зарцуулсан байна.

Дүрслэл-3 Хөдөлмөр эрхлэлтийн сургалтад хамрагдсан иргэдийн мэдээлэл



ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН СУРГАЛТЫН ГҮЙЦЭТГЭЛ, ӨСӨЛТ БУУРАЛТ (2023-2025 ОН) /иргэний тоогоор/



Сургалтын төрөл	Нийт хамрагдсан иргэдийн тоо	Байгууллагаар				Нийт
		Архангай МСУТ	Булган МСУТ	Хоршооны мэдээлэл сургалтын төв	Сонор эдүкейшн центр ХХК	
Аж ахуй эрхлэлтийн сургалт	935	120	353	403	59	935
Залуучуудын сургалт, зөвлөгөө	120	40	80	0	0	120
Танхимын сургалт зохион байгуулах	107	10	67	20	10	107
Суурь ур чадвар	137	57	70	0	10	137
Эмэгтэйчүүдэд зориулсан богино хугацааны ур чадварын сур.	31	6	0	25	0	31
НИЙТ	1,330	233	570	448	79	1,330



Нийт 1,330 иргэн 5 төрлийн сургалтад хамрагдсан.
/2023-2025 ОН/



Хамгийн өндөр: Аж ахуй эрхлэлтийн сургалт – 935 иргэн (70.3%).
/2023-2025 ОН/



Хамгийн бага: Эмэгтэйчүүдэд зориулсан богино хугацааны сургалт – 31 иргэн (2.3%).
/2023-2025 ОН/

Хөдөлмөрт бэлтгэх сургалтад 2023-2025 онд хамрагдсан 1330 иргэнээс 43 иргэн гар урлал, 75 иргэн тогооч, 45 иргэнийг цахилгаанчны сургалтад хамруулж, нийт 163 иргэнд чадамжийн гэрчилгээ олгожээ.

Сүүлийн 3 жилд сургалтад хамрагдсан иргэдийн судалгаанаас харахад тогооч, цахилгаанчин, гар урлалын сургалтаас өөр сургалтыг зохион байгуулаагүй бөгөөд ХХҮГ-аас сургалтын эрэлт хэрэгцээнд дүн шинжилгээ хийгээгүй, зах зээлийн эрэлт хэрэгцээг тодорхойлоогүй байна.

• Санхүүгийн дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа:

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1¹³-д заасны дагуу санхүүгийн дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаанд 2023-2025 онд 799 иргэнд 6,593.2 сая төгрөг батлагдаж, гүйцэтгэлээр 948 иргэнд 6,504.4 сая төгрөг, төгрөгийг зарцуулжээ.

Аудитаар 2023-2025 онд санхүүгийн дэмжлэгт хамрагдсан 5 сумын 38 төсөл хэрэгжүүлэгчийн үйлдвэрлэл, үйл ажиллагаа, ажлын байраа хадгалсан, нэмэгдүүлсэн байдал, дэмжлэг, зээлийн эргэн төлөлтийг газар дээр нь шалгаж, үнэлэлт дүгнэлтийг өгсөн. Иргэнд олгох санхүүгийн дэмжлэгт хамрагдаж, үйл ажиллагаагаа өргөжүүлэн ажлын байраа нэмэгдүүлсэн, мөн ахмад болон ХБИ-ний дэмжлэгт хамрагдсан иргэний зарим төсөл арга, хэмжээг авч үзвэл:

¹³ Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанд ажил хайгч, ажилгүйдэлд өртөж болзошгүй иргэн, ажил олоход хүндрэлтэй иргэн, малчин, мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын төгсөгч бичил үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч, хувиараа хөдөлмөр эрхлэгч болон нөхөрлөл, хоршоо байгуулах иргэн, ажил олгогч энэ хуульд заасны дагуу хамрагдана



Өндөр-Улаан сум Талхны цех: 2024 онд иргэнд олгох санхүүгийн дэмжлэгт хамрагдаж 10.0 сая төгрөгийн зээлээр тоног төхөөрөмж худалдан авсан байна. Төсөл хэрэгжсэнээр өдөрт 200-400 ширхэг талх үйлдвэрлэж, сумын талхны хэрэгцээг бүрэн хангаж байна. Мөн зээлийн үр дүнд цехийн үйл ажиллагаа өргөжиж, байнгын 1, түр 1, нийт 2 ажлын байр шинээр бий болгож, үр дүнгээ өгсөн байна.



Тариат сум Блокны үйлдвэр: Иргэнд олгох санхүүгийн дэмжлэгт 2025 онд хамрагдаж 10.0 сая төгрөгийн зээлийг авч түүхий эд материал, тоног төхөөрөмж бэлтгэсэн бөгөөд өдөрт дунджаар 200-300 блок үйлдвэрлэн, Эрдэнэбулган, Хангай, Цахир сумд болон Хөвсгөл аймгийн зарим сумдад борлуулж байна. Төслийн үр дүнд ажлын байраа хадгалж өрхийн орлогоо нэмэгдүүлэхийн зэрэгцээ 2-3 иргэнийг түр ажлын байр буюу улирлын чанартай ажлын байраар хангаж байна..

Ихтамир сум гар урлал: Ахмадад олгох санхүүгийн дэмжлэгт 2025 онд хамрагдаж 10.0 сая төгрөгийг авч, үндэсний гар урлалын түүхий эдийг татан авснаар монгол гутал, гөлөм, бусад арьсан урлалын үйлдвэрлэлийг тасралтгүй явуулах нөхцөлийг бүрдүүлжээ. Бүтээгдэхүүнээ зах зээлд борлуулан, ажлын байрыг тогтвортой хадгалж байна. Түүнчлэн “Архангай түншлэл” арга хэмжээнд тогтмол оролцож, брэнд бүрдүүлэлт, сурталчилгааг идэвхтэй хийж байна.



Тариат сум цагаан идээ: Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд олгох санхүүгийн дэмжлэгт 2024 онд хамрагдаж 6.0 сая төгрөгийг 50 хувийг буцаан төлөх нөхцөлтэй зээлийг авч, цагаан идээний сав, баглаа боодлыг стандартын шаардлагад нийцүүлэн шинэчилж, брэндийн лого, дардастай болсноор бүтээгдэхүүний стандарт шаардлагыг хангаж, эко савлагаатай, өнгө үзэмж сайтай болсон байна. Зун, намрын улиралд бүтээгдэхүүнээ байнга борлуулж, 5.0-10.0 сая төгрөгийн тогтвортой орлоготой болсон байна.



Аудитад хамрагдсан 38 төсөл, арга хэмжээний зөвхөн 2 төсөл нь үйлдвэрлэлээ өргөтгөж, 3-4 байнгын болон түр ажлын ажлын байрыг бий болгосон хэдий ч цалин хөдөлмөрийн хөлснөөс НДШ болон ХХОАТ-ыг төлснийг нотлох баримтгүй байна.

ХЭДС-ийн хөрөнгө нь батлагдсан төсөв, хөтөлбөрийн дагуу үндсэндээ зарцуулагдсан боловч уг зарцуулалтын үр дүнд аймгийн хэмжээнд бодит, тогтвортой шинэ ажлын байр цөөн бий болж, ихэнх тохиолдолд зөвхөн одоо байгаа ажлын байрыг хадгалах, өрхийн орлогыг тодорхой хэмжээнд нэмэгдүүлэхэд чиглэгдсэн байна.

• Түр ажлын байрны дэмжих үйл ажиллагаа:

Ногоон хөгжлийн болон нийтийн шинж чанартай ажилд ажилгүй иргэдийн оролцох боломжийг хангах, ажилгүй, ажил олоход хүндрэлтэй зорилтот бүлгийн иргэдэд түр хугацааны хөдөлмөр эрхлэх боломжийг нэмэгдүүлэх зорилгоор 2023-2025 онд мод тарих, нийтийг хамрах ажил, ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээнд **2328** иргэнийг хамруулж **880.1** сая төгрөгийн санхүүжилтийг олгосон байна.

Дүрслэл-4: ХЭДС-аас 2023-2025 онд түр ажлын байранд хамрагдсан иргэдийн судалгаа



Зорилтот бүлгийн иргэд түр ажлын байранд хамрагдсанаар цаашид ажил хийх, ажил хайх суурь тавигдсан эсэх, тодорхой хэмжээнд орлогын их үүсвэр нэмэгдэж, өөрчлөлт гарсан эсэхийг үнэлж, үр дүнг тооцдоггүй байна.

2.1.2. Санхүүгийн дэмжлэгийг олон төсөлд хуваан олгож байгаа нь төслийн үр нөлөөг буруулж, ажлын байр нэмэгдүүлэх боломжийг алдагдуулж байна

Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 340 дүгээр тогтоолоор баталсан "Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас жижиг зээл олгох, түүнд батлан даалт гаргах, хүүг нь нөхөн төлөх, санхүүгийн дэмжлэг үзүүлэх журам"-ын 5.1.1¹⁴, 5.1.2¹⁵, 5.3.1¹⁶-д заасныг 2024 оны 209 дүгээр тогтоолоор нэмэлт, өөрчлөлт оруулж, малгүй, цөөн малтай малчныг малжуулахад олгох санхүүгийн дэмжлэгийн хэмжээг 5.0 сая төгрөг байсныг 8.0 сая төгрөг, иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанд олгох санхүүгийн дэмжлэгийн дээд хэмжээг 10.0 сая төгрөг байсныг 20.0 сая төгрөг болгон нэмэгдүүлжээ.

¹⁴ малгүй, цөөн малтай малчныг малжуулахад 5.0 сая төгрөг,

¹⁵ иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанд 10.0 сая хүртэл төгрөгийн санхүүгийн дэмжлэг олгохоор,

¹⁶ хөгжлийн бэрхшээлтэй иргэн 5.2.1-д заасан төслийг хэрэгжүүлсэн тохиолдолд санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөлтийг 50 хүртэл хувиар хөнгөлөхөөр



Дүрслэл 5: ХЭДС-аас 2023-2025 онд олгосон иргэн, ахмад, ХБИ-д олгосон санхүүгийн дэмжлэгийн судалгаа



АЙМГИЙН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ДЭМЖИХ САНГААС
ИРГЭН, АХМАД, ХБИ-Д ОЛГОХ САНХҮҮГИЙН ДЭМЖЛЭГИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ, ГҮЙЦЭТГЭЛ
(2023-2025 ОН)

Огноо	Дэмжлэгийн төрөл	Төлөвлөгөө			Гүйцэтгэл		
		Хүний тоо	Мөнгөн дүн	Дундаж мөнгөн дүн	Хүний тоо	Мөнгөн дүн	Дундаж мөнгөн дүн
2023	Иргэнд олгох санхүүгийн дэмжлэг	70	700.0	10.0	92	700.0	7.6
	Ахмадад олгох санхүүгийн дэмжлэг	24	120.0	5.0	41	120.0	2.9
	ХБИ-д олгох санхүүгийн дэмжлэг	18	144.0	8.0	23	144.0	6.3
2024	Иргэнд олгох санхүүгийн дэмжлэг	45	450.0	10.0	52	450.0	8.7
	Ахмадад олгох санхүүгийн дэмжлэг	30	240.0	8.0	48	240.0	5.0
	ХБИ-д олгох санхүүгийн дэмжлэг	16	128.0	8.0	20	128.0	6.4
2025	Иргэнд олгох санхүүгийн дэмжлэг	60	900.0	15.0	103	900.0	8.7
	Ахмадад олгох санхүүгийн дэмжлэг	30	300.0	10.0	50	300.0	6.0
	ХБИ-д олгох санхүүгийн дэмжлэг	20	200.0	10.0	32	200.0	6.3
Нийт дүн		313	3,182.0	10.2	461	3,182.0	6.9

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 209 дүгээр тогтоолоор хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанд нэг иргэнд олгох санхүүгийн дэмжлэгийн хэмжээг нэмэгдүүлэн баталсан хэдий ч ХХҮЕГ-аас нэг иргэнд олгох санхүүжилтийн дундаж хэмжээг 2024 онд 10.0 сая төгрөг, 2025 онд 15.0 сая төгрөг байхаар баталсан байна.

ХЭДС-аас 2023-2025 онд иргэн, ахмад, ХБИ-д олгох сангийн дэмжлэгт нийт 3,182.0 сая төгрөгийг 313 иргэнд буюу дунджаар нэг иргэнд 10.2 сая төгрөгийг олгохоор баталсан байхад гүйцэтгэлээр 461 иргэнд буюу дунджаар нэг иргэнд 6.9 сая төгрөгийн санхүүжилтийн олгосон байна.

Нэг иргэнд ногдох санхүүжилтийг бууруулан төсөл, хөтөлбөрт хамрагдагчдын тоог нэмэгдүүлэн олгосон нь төслийн санхүүжилтийг хэт жижиглэн хуваарилж, санхүүгийн дэмжлэгийн үр дүнг бууруулан, сум, орон нутагт шинэ ажлын байр бодитоор бий болгох боломжийг алдагдуулсан байна.

Хүснэгт-3: ХЭДС-аас 2023-2025 онд төсөл арга хэмжээнд хамрагдсан иргэдийн ажлын байрны мэдээлэл

№	Сумын нэр	2023			2024			2025			Нийт бий болсон ажлын байр
		Хамрагдсан иргэдийн тоо	олгосон санхүүжилт	ажлын байр	Хамрагдсан иргэдийн тоо	олгосон санхүүжилт	ажлын байр	Хамрагдсан иргэдийн тоо	олгосон санхүүжилт	ажлын байр	
1	Өндөр Улаан	9	54.0	9	6	36.0	6	8	50.0	8	23
2	Цэцэрлэг	4	17.0	4	2	17.0	2	5	50.0	5	11
3	Тариат	4	22.0	4	10	60.0	10	9	65.0	9	23
4	Хашаат сум	2	9.0	2	1	10.0	1	6	40.0	6	9
5	Ихтамир	5	32.0	5	5	28.0	5	8	68.0	8	18
6	Хайрхан	4	16.0	4	3	27.0	3	11	65.0	11	18
7	Булган	4	30.0	4	5	33.0	5	5	34.0	5	14
8	Төвшрүүлэх	5	34.0	5	5	35.0	5	8	49.0	8	18
9	Хангай	8	47.0	8	4	31.0	4	8	62.0	8	20



10	Хотонт	2	12.0	2	4	25.0	4	4	33.0	4	10
11	Чулуут	8	52.0	8	6	37.0	6	8	75.0	8	22
12	Цахир	1	2.0	1	2	19.0	2	6	45.0	6	9
13	Өгийнуур	5	24.0	5	4	31.0	4	7	61.0	7	16
14	Өлзийт	7	40.0	7	4	25.0	4	9	70.0	9	20
15	Эрдэнэмандал	7	46.0	7	6	35.0	6	7	63.0	7	20
16	Батцэнгэл	11	57.0	11	8	50.0	8	7	40.0	7	26
17	Цэнхэр	8	41.0	8	3	23.0	3	7	57.0	7	18
18	Жаргалант	3	20.0	3	5	30.0	5	7	45.0	7	15
19	Эрдэнэбулган	60	414.0	60	37	266.0	37	54	423.0	54	151
Нийт дүн		157	969.0	157	120	818.0	120	184	1,395.0	184	461

ХЭДС-аас 2023-2025 онд төсөл, хөтөлбөрт хамрагдсан 461 иргэний амьжиргааны түвшин тодорхой хэмжээгээр өсөж байгаа ч орон нутгийн хэмжээнд бодитой шинэ ажлын байр бий болгох нөхцөл бүрдээгүй, зөвхөн төсөлд хамрагдсан иргэд өөрийн ажлын байраа хадгалж, төсөл хэрэгжүүлэгчээс ирүүлсэн төсөлд тусгагдсан хэрэгцээ, шаардлага, хүссэн санхүүжилтийн хэмжээнд дэмжлэгийг олгоогүй, хэт жижиглэн хуваарилж байгаа нь төслийн үр ашгийг бууруулах гол шалтгаан болж байна.

Санхүүжилтийг хэт жижиглэж олгосон нь иргэд бизнесээ бодитой өргөжүүлж, шинэ ажлын байр нэмэлтээр бий болгох боломжийг хязгаарлаж байна.

Иймд төсөл, хөтөлбөрүүдийн хүрэх үр дүнг бодитой тооцож, цаашид санхүүжилтийн хэмжээг тухайн үйл ажиллагааны цар хүрээ, бодит ажлын байр бий болгох чадамжтай нь уялдуулан үе шаттай нэмэгдүүлэх шаардлагатай байна.

Дүрслэл-6: Санхүүгийн дэмжлэгийн чиглэл ангиал

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас 2023-2025 олгосон нийт төсөл хөтөлбөрийн 1,019.5 сая төгрөг буюу 32 хувь нь оёдол, гар урлалын үйлдвэрлэлд, 581.0 сая төгрөг буюу 18 хувь нь хоол үйлдвэрлэлийн чиглэлд, 445.0 сая төгрөг буюу 14 хувь нь сүү, сүүн бүтээгдэхүүн цагаан идээний үйлдвэрлэлд, 315.0 сая төгрөг буюу 10 хувь нь засвар үйлчилгээний салбарт, үлдсэн 886.5 сая төгрөг буюу 26 хувь нь бусад салбарын үйлдвэрлэлд олгогдсон байна.



2.1.3. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн хөтөлбөр, арга хэмжээний үр нөлөөг тооцож үнэлээгүй байна

Хөдөлмөр эрхлэлтийн аймгийн зөвлөл нь Хөдөлмөр эрхлэлтийн Үндэсний зөвлөлийн 2017 оны 02 дугаар тогтоолоор батлагдсан “Аймаг, нийслэл, дүүргийн зөвлөлийн дүрэм”-ийн 2.2.4-д заасан “Тухайн орон нутагт хэрэгжсэн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээ, арга хэмжээ, хөтөлбөр, төслийн үр дүн, нөлөөлөлд жил бүр үнэлгээ хийж, санал, дүгнэлт гаргах” үүргийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Аудитаас аймгийн хөдөлмөр эрхлэлтийн зөвлөл нь 2023-2025 онд хөдөлмөр эрхлэлтийн дэмжих сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн хөтөлбөрийн үр нөлөөг тооцож холбогдох арга хэмжээг авч ажиллаагүй зөрчлийг арилгах албан шаардлагыг аймгийн Хөдөлмөр эрхлэлтийн зөвлөлд хүргүүлээ.



2.1.4 Санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөлтийг 2023,2024 онд төлөвлөөгүйгээс 805.5 сая төгрөгийн эх үүсвэрийг дутуу бүрдүүлсэн байна

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 22 зүйлийн 22.1-д зааснаар хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн орлого нь 9 төрлийн эх үүсвэрээс бүрддэг бөгөөд аймгийн ХЭДС-ийн хувьд тус сангийн орлого нь хуулийн 22.1.1¹⁷, 22.1.7¹⁸, 22.1.8¹⁹-д заасан орлогын дараах эх үүсвэрээс бүрдэж байна.

Хүснэгт-4: ХЭДС-ийн 2023-2025 оны нийт орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл
(сая төгрөг)

Үзүүлэлт	2023 он		2024 он		2025 он	
	төлөвлөгөө	Гүйцэтгэл	төлөвлөгөө	Гүйцэтгэл	төлөвлөгөө	Гүйцэтгэл
Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг ажиллуулаагүй аж ахуйн нэгж, байгууллагаас төлөх төлбөр	3.5	10.4	-	9.9	7.2	43.1
Улсын төсвөөс хуваарилсан санхүүжилт	1,917.2	1,917.2	4,146.3	4,146.3	1,935.7	1,915.7
Санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөгдсөн хөрөнгө	-	735.1	-	970.3	650.0	1,630.6
Өмнөх оны үлдэгдэл			91.0	91.0		

Эх сурвалж:ХХҮГ-ын тайлангаас

Хөдөлмөрийн тухай хуулийн 144 зүйлийн 144.2²⁰,144.3²¹ дахь заалтын хүрээнд Хөгжлийн бэрхшээлтэй буюу одой иргэнийг ажиллуулаагүй төлбөрийн орлогыг 2023 онд 3.5 сая төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 10.4 сая төгрөг, 2024 онд орлого төлөвлөөгүй, 2025 онд 7.2 сая төгрөгийг төлөвлөж, гүйцэтгэлээр 43.1 сая төгрөгийг орлогыг ААН байгууллагуудаас бүрдүүлжээ. Тус төлбөрийн орлого 63.4 сая төгрөгийг хөдөлмөр эрхлэлтийг дэмжих дэд санд төвлөрүүлсэн байна.

Аймгийн хэмжээнд 2023-2025 оны байдлаар үйл ажиллагаа явуулж буй 25 ба түүнээс дээш ажилтантай нийт 94 байгууллагад хуулийн дагуу 164 ХБИ-ийн ажиллахаас 46 иргэн ажиллаж, 118 иргэнийг ажиллуулаагүй тухай судалгааг ХХҮГ-аас ирүүлсэн байна.

Аймгийн ХХҮГ-ынн хөдөлмөр, аюулгүй байдал хариуцсан мэргэжилтэн Хөдөлмөрийн тухай хуулийн 144.2, 144.3 дахь заалтыг хэрэгжүүлэхээр байгууллагуудад зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэн ажиллаж байгаа хэдий ч орлого бүрдүүлэлт хангалтгүй байна.

Аудитаас Хөдөлмөрийн тухай хуулийн 144 зүйлийн 144.2, 144.3 дахь заалтын дагуу орлого бүрэн төвлөрүүлэх арга хэмжээг зохион байгуулж ажиллах албан шаардлагыг ХХҮГ-т хүргүүлээ.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн орлогын эх үүсвэрийг хуульд заасны дагуу улсын төсвөөс 2023 онд 1,917.2 сая төгрөг, 2024 онд 4,146.3 сая төгрөг, 2025 онд 1,935.7

¹⁷ Улсын төсвөөс хуваарилсан хөрөнгө

¹⁸ Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг ажиллуулаагүй аж ахуйн нэгж, байгууллагаас төлөх төлбөр

¹⁹ Жижиг зээл, санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөгдсөн хөрөнгө

²⁰ “Өмчийн төрөл, хэлбэрээс үл хамаарч 25 ба түүнээс дээш ажилтантай аж ахуйн нэгж, байгууллага нийт ажлын байрныхаа дөрвөн хувиас доошгүй орон тоонд хөгжлийн бэрхшээлтэй хүнийг ажиллуулна”,

²¹ “Аж ахуйн нэгж, байгууллага энэ хуулийн 144.2-т зааснаар хөгжлийн бэрхшээлтэй хүн ажиллуулаагүй бол ажиллуулбал зохих орон тоо тутамд ногдох төлбөрийн хэмжээ нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй тэнцүү байх бөгөөд уг төлбөрийг сар бүр Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих дэд санд төлнө”



сая төгрөгөөр тус тус төлөвлөж, 2023,2024 онд төлөвлөсөн орлогыг бүрэн авч, 2025 онд батлагдсан төлөвлөгөөнөөс 20.0 сая төгрөгөөр дутуу санхүүжилт авчээ.

Санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөлтийг 2023-2024 онд төлөвлөөгүй харин 2025 онд 650.0 сая төгрөгийн төлөвлөж, гүйцэтгэлээр 1,630.6 сая төгрөгийн орлогыг бүрдүүлсэн байна.

ХЭДС-аас 2023 онд 221 иргэнд нийт 1,290.0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг олгосон бөгөөд гэрээний хугацаа дууссан 67 иргэний 199.6 сая төгрөгийн зээлийг барагдуулаагүй байна.

Хүснэгт-5: ХЭДС-аас 2023 онд олгосон зээлийн гэрээний хугацаанд төлөгдөөгүй дүн

Хөтөлбөр, арга хэмжээ	Санхүүгийн дэмжлэгт хамрагдсан иргэдийн тоо	Олгосон мөнгөн дүн	Төлөх дүн	Зээлийн үлдэгдэл 6 сарын 15-ны байдлаар	(сая төгрөг)	
					Аудит явцад төлсөн дүн	Нийт төлбөл зохих дүн
Хувиараа хөдөлмөр эрхлэгч	24	266	120.7	120.7	22.2	98.5
Ахмадад олгох санхүүгийн дэмжлэг	3	30	10	9.4	4.3	5.1
Хөгжлийн бэрхшээлтэй иргэний дэмжлэг	3	15.1	4.3	4.3	0.9	3.4
Малжуулах төсөл хөтөлбөр	37	160	146.5	116.7	24.1	92.6
Нийт	50	471.1	281.5	251.1	51.5	199.6

Аудитаас гэрээний үүргээ биелүүлээгүй 15 сумын 67 иргэнтэй холбоотой 199.6 сая төгрөгийн хугацаа хэтэрсэн зээлийг хөдөлмөр эрхлэлтийн дэмжих санд буцаан төвлөрүүлэх төлбөрийн актыг тогтоож, ХХҮГ-т хүргүүллээ.

Мөн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас 2024-2025 онд нийт 392 иргэнд 1,969.9 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг олгосноос 399 иргэнтэй холбоотой 605.9 сая төгрөгийн зээлийг графикийн дагуу төлөөгүй байна.

Хүснэгт-6: ХЭДС-аас 2024-2025 онд олгосон санхүүгийн дэмжлэгийг зээлийн эргэн төлөлт

(сая төгрөгөөр)

Хөтөлбөр, арга хэмжээ	Олгосон санхүүгийн дэмжлэг		Графикийн дагуу төлөөгүй зээлийн дүн	
	Хүний тоо	Мөнгөн дүн	Хүний тоо	Мөнгөн дүн
Иргэнд олгох санхүүгийн дэмжлэг	101	215.0	100	145.3
Ахмадын санхүүгийн дэмжлэг	55	89.9	52	65.2
Малжуулах хөтөлбөр	203	1,624.0	222	385.8
Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд олгох дэмжлэг	33	41.0	25	9.6
Дүн	392	1,969.9	399	605.9

Аудитаас Зээлийн гэрээний хавсралтад заасан графикийн дагуу эргэн төлөлт хийгээгүй 399 иргэнтэй холбоотой 605.9 сая төгрөгийг хөдөлмөр эрхлэлтийн дэмжих санд буцаан төвлөрүүлэх албан шаардлагыг ХХҮГ-т хүргүүллээ.

2.2. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанд хуульд заасан эрх бүхий байгууллагаас хяналт-шинжилгээ, үнэлгээ хийгдээгүй байна

2.2.1 ХЭДС-ийн үйл ажиллагааны үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийгдээгүй байна

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.2²², “Засгийн газрын 2011 оны 375 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Хөдөлмөр

²² “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны үр дүнд хөндлөнгийн байгууллагаар жил бүр хяналт, шинжилгээ, үнэлгээ хийлгэнэ”



эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгийг бүрдүүлэх зарцуулах, хяналт тавих журам”-ын 5 дугаар зүйлийн 5.4²³-д заасны дагуу мэргэшсэн байгууллагаар хяналт, үнэлгээ хийлгэхээр заасан байна. Тус хууль, журмын дагуу 2023-2025 оны ХЭДС-ийн хөрөнгийн зарцуулалтад мэргэжлийн байгууллагын хяналт шинжилгээ, үнэлгээ хийгдээгүй байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.2-т заасан хяналт шинжилгээ, үнэлгээ хийх байгууллагыг Гэр бүл, хөдөлмөр нийгмийн хамгааллын яамнаас сонгон шалгаруулдаг бөгөөд Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд хөндлөнгийн байгууллагын хяналт хийлгэх төсвийг батлаагүй тул 2023-2025 онд хөндлөнгийн байгууллагаас хяналт шалгалт хийгдээгүй байна. (ХХҮГ-ын 2026 оны 07 дугаар сарын 01-ны өдрийн 01/123 тоот албан бичиг)

Засаг даргын тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсээс ХЭДС-ийн 2023-2025 оны хөрөнгөөр хэрэгжүүлсэн хөтөлбөр, арга хэмжээний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ үнэлгээ хийгдээгүй. Харин аймгийн аймгийн Засаг даргын 2020-2024 он, 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн 2023-2025 оны хөгжлийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн бөгөөд үнэлгээний дундаж 90.9 хувьтай байна.

Дүрслэл-7: Бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд хийсэн ХШҮ Эх сурвалж: Аймгийн

ЗДТГ-ын хяналт шинжилгээ үнэлгээний тайлангаас

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.5²⁴, 30.1.6²⁵, Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2017 оны 02 дугаар тогтоолоор баталсан “Хөдөлмөр эрхлэлтийн аймаг, нийслэл, дүүргийн зөвлөлийн дүрэм”-ийн 2.2.3²⁶ “2.2.9²⁷-д хөдөлмөр эрхлэлтийн үйл ажиллагаа, сангийн хөрөнгийн зарцуулалт, арга хэмжээний

²³ Сангийн үйл ажиллагаанд мэргэшсэн байгууллагаар хөндлөнгийн үнэлгээ хийлгэж, Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлд жил бүр танилцуулна”

²⁴ Төрийн захиргааны төв байгууллага нь хөдөлмөр эрхлэлтийн байгууллагыг бодлогын удирдамж, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж, хяналт тавих бүрэн эрхийг хэрэгжүүлнэ”,

²⁵ хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны эх үүсвэр, төсөв, тусгай зориулалтын сан, төсөл, хөтөлбөрийн хөрөнгийн төлөвлөлт, хуваарилалтыг хийх, зарцуулалтад хяналт тавих, үнэлж дүгнэх

²⁶ Зөвлөл нь хөдөлмөр эрхлэлтийг дэмжих дэд сангийн орлого, зарлагын явц, байдал, үүний дотор хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн жижиг зээлийн эргэн төлөлтийн байдалд хяналт тавих үүрэгтэй”,

²⁷ Үндэсний зөвлөлийн ажлын албанаас гаргасан аргачилсан удирдамж, зөвлөмжийг үндэслэн зөвлөлийн гишүүдийн ажил үүргийн хуваарь, томилсон байгууллагадаа ажлаа тайлагнах болон удирдан зохицуулах, хяналт үнэлгээ хийхдээ ашиглах шалгуур үзүүлэлтүүд зэргийг үйл ажиллагаандаа нийцүүлэн баталж хэрэгжүүлэх үүрэгтэй



хэрэгжилтэд төрийн захиргааны төв байгууллага, аймгийн хөдөлмөр эрхлэлтийн зөвлөл хяналт хэрэгжүүлэхээр тусгагдсан.

ХХҮЕГ-ын даргын 2024 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн А/75 дугаар тушаалын дагуу аймгийн ХХҮГ-аас сангийн 2023 оны үйл ажиллагаанд төлөвлөгөөт хяналт шалгалтыг хийсэн бөгөөд харин 2024-2025 онд хяналт, шалгалт хийгдээгүй байна.

Мөн ХЭДС-ийн үйл ажиллагаанд хуулиар хүлээсэн чиг үүргийн дагуу Хөдөлмөр эрхлэлтийн зөвлөлөөс хөндлөнгийн хяналтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Аудитаас хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн үйл ажиллагаанд хяналт хийж, сангийн тайланг хагас бүтэн жилээр хэлэлцэх арга хэмжээг авч, зөрчлийг арилгах албан шаардлагыг аймгийн Хөдөлмөр эрхлэлтийн зөвлөлд хүргүүлээ

2.2.2. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг хэрэгжүүлсэн ч хяналтын үр нөлөө сул байна

Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолын 3.4²⁸. 3.5²⁹-д заасны дагуу аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 2023 оны дотоод хяналтын төлөвлөгөөнд ХЭДС-ийн үйл ажиллагаа, хөрөнгийн зарцуулалт, төсөл хөтөлбөрийн хэрэгжилт, нийтлэг үйлчилгээнд хяналт шалгалт хийх 3 арга хэмжээг тусгаж хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- “Эргэн төлөлт-2023” аяны хүрээнд 19 суманд санхүүгийн дэмжлэгт хамрагдсан төсөл хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт шалгалт хийсэн боловч дотоод хяналт шалгалтын үр дүнгээр хөдөлмөр эрхлэлтийн бодлого, төсөл хөтөлбөрийн хэрэгжилтийг сайжруулах зөвлөмж, чиглэл боловсруулж хүргүүлээгүй байна.
- ХХҮГ-ын даргын баталсан удирдамжийн дагуу Захиргаа хяналтын хэлтсээс Эрдэнэбулган сумын 2024-2025 онд ХЭДС-аас төсөл, хөтөлбөрт хамрагдсан 16 иргэний үйл ажиллагаанд хяналт шалгалт хийсэн байна. Уг шалгалтаар санхүүгийн дэмжлэгийг зориулалтын дагуу зарцуулсан байдал, үйл ажиллагааны тогтвортой байдал, зээлийн эргэн төлөлт, гэрээний хэрэгжилтэд үнэлгээ хийж тайлагнасан боловч дотоод хяналт, шалгалтыг үр дүнг тооцсон эсэх нь тодорхойгүй байна.

ХХҮГ-аас 2024-2025 онд дотоод хяналт шалгалтыг иж бүрэн, үр нөлөөтэй зохион байгуулаагүй байна

Аудитаас Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг сайжруулах, хяналт шалгалтын үр дүн, үр нөлөөг тооцож ажиллах албан шаардлагыг аймгийн ХХҮГ-т хүргүүлээ.

²⁸ Дотоод хяналт шалгалтын нэгж, ажилтан нь тухайн аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааны онцлог, үйлдвэрлэл, үйлчилгээний чиглэл, хэмжээ, зохион байгуулалтын бүтэц, харьяалагдах нэгж, объектын тоог харгалзан тухайн жилд хийх хяналт шалгалтын ажлын тусгайлсан төлөвлөгөөг боловсруулан эрх бүхий албан тушаалтнаар батлуулан мөрдөж ажиллана.

²⁹ Дотоод хяналт шалгалтын нэгж, ажилтан нь хяналт шалгалтын ажлын дүн, авсан арга хэмжээний талаар улиралд нэгээс доошгүй удаа тухайн аж ахуйн нэгж, байгууллагын удирдлагын хурлаар хэлэлцүүлж, шаардлагатай бол шийдвэр гаргуулан хамт олонд мэдээлнэ



ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлд тулгуурлан дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн санхүүжилтийг орон нутгийн бодит хэрэгцээ, эрэлтэд нийцүүлэн бодитой төлөвлөх шаардлагатай байна
- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр арга, хэмжээг бодлогын түвшинд үйл ажиллагааны хөтөлбөр, төлөвлөгөөтэй уялдуулсан байна
- Аймгийн хөдөлмөр эрхлэлтийн зөвлөл нь дүрэмд заасан чиг үүргээ бүрэн хэрэгжүүлээгүй, сангийн хөрөнгийг зах зээлийн бодит хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн үндэслэлтэй төлөвлөөгүй байна
- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн хөтөлбөр, арга хэмжээ нь сангийн үндсэн зорилгыг хангахуйц үр дүнг бий болгоогүй байна
- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас хэрэгжүүлсэн хөтөлбөр, арга хэмжээний үр дүнд ажлын байр бодитой нэмэгдээгүй байна
- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанд хуульд заасан эрх бүхий байгууллагаас хяналт- шинжилгээ, үнэлгээ хийгдээгүй байна

АУДИТЫН ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ:

ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ ЧИГЛЭЛЭЭР ХЭРЭГЖҮҮЛСЭН ХӨТӨЛБӨР АРГА ХЭМЖЭЭНИЙ ҮР ДҮН ХАНГАЛТГҮЙ БАЙНА

Аудитын дүн: Аудитаар нийт 805.5 сая төгрөгийн зөрчил илэрсэнд зөрчлийг таслан зогсоох, давтан гаргахгүй байх 605.9 сая төгрөгийн 7 албан шаардлага, 199.6 сая төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, аймгийн хөдөлмөр эрхлэлтийн зөвлөл, ХХҮГ-ын холбогдох албан тушаалтнуудад хүргүүллээ.



ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ ТАЙЛБАР:



АРХАНГАЙ АЙМАГ ХӨДӨЛМӨР, ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗАР

Г.Дэмид жанжины гудамж, 3-307 тоот, 1 дүгээр баг,
Эрдэнэбулган сум, Архангай аймаг, 65141

Утас: 77331220, Факс: (976)77331220

Цахим шуудан: info@arkhangai.hudulmur-halamj.gov.mn

Цахим хуудас: www.arkhangai.hudulmur-halamj.gov.mn

2026.07.07

№

01/225

танай _____-ны № _____-т

┌ АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН ┐ АУДИТЫН ГАЗАРТ

Тус газраас ирүүлсэн "Халамжаас хөдөлмөрт бодлогын хүрээнд аймагт хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн, үр нөлөө" сэдэвт гүйцэтгэлийн аудитын тайлантай танилцан тухайлсан саналгүй болохоо илэрхийлж байна.



Архангай аймгийн Хөдөлмөр,
халамжийн үйлчилгээний газар
Удирдлага
Дарга
Шагдарсүрэн Гомбодорж
2026-07-07 15:11:48



АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ

2026 оны 07 сарын 08 өдөр

Дугаар А/27

Эрдэнэбулган сум

Гүйцэтгэлийн аудитын тайлан
баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 29 дүгээр зүйлийн 29.4 дэх заалт, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн А/106 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын 18 дугаар зүйлийн 18.9 дэх хэсэг, 2025 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн "Эрх шилжүүлэх тухай" А/175 дугаар тушаалын гуравдугаар хавсралтын 3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Өөрийн төлөвлөгөөний дагуу "Халамжаас хөдөлмөрт бодлогын хүрээнд аймагт хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн, үр нөлөө"-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг баталсугай.

2. Аудитаар хүргүүлсэн акт, албан шаардлагыг хавсралтаар баталсугай.

3. Аудитын тайланг Аймгийн хөдөлмөр халамж үйлчилгээний газар, Аймгийн хөдөлмөр эрхлэлтийн зөвлөл, аймгийн Засаг дарга болон ИТХ-ын даргад хүргүүлэхийг аудитор (Н.Дашмягмар)-д даалгасугай.

4. Аудитын тайлан баталгаажуулснаас хойш 14 хоногт багтаан аудитын ажлын баримтыг архивын нэгж болгон хүлээлгэн өгөхийг аудитор (Н.Дашмягмар), аудитор (Н.Энхчимэг) нарт үүрэг болгосугай.

5. Аудитын шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аудитын менежер (Н.Алтантуяа), тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг эрх зүйч аудитор (Б.Анхтуяа)-д даалгасугай.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Т.БАЙГАЛМАА